



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 20

Арвайхээр

“Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2016-2020 онд баримтлах чиглэл”-ийг хэрэгжүүлэх  
ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын “Үндсэн хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1, 62.2 дахь, “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх, сумын ИТХурлын Төлөөлөгчдийн 2016 оны 2/06 дугаар тогтоолоор батлагдсан “Чиглэл батлах тухай” тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд баримтлах чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2 бүлэг, 47 бодлогын зорилт, арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Баримтлах чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийн явц үр дүнг тооцон биелэлтийг жил бүр дүгнэж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн жилийн үйл ажиллагааны тайланд тусган мэдээлж ажиллахыг сумын ИТХ-ын Ажлын албаны дарга /Ц.Тунгалаг/-д үүрэг болгосугай.



ДАРГА *[Signature]* Д.АМАРТҮВШИН